

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 28/01

Улаанбаатар хот

### Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бодь даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “Хавсралт №1”-т заасны дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

“Бодь даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
хурлын №23/01 тоот тогтоолын Хавсралт №1



## САНХҮҮГИЙН ТАЙЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

2022 онд Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 4.8 хувь, инфляцын түвшин 13.2 хувь гарсан бол даатгалын салбарын цэвэр хураамж 25.5 хувиар өссөн байна. Цэвэр хураамжийн өсөлтөд тээврийн хэрэгслийн даатгалын хураамж болон гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгалын хэлбэрт цэвэр хураамж өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

“Бодь Даатгал” ХК-ийн хувьд 2022 онд санхүүгийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай гарсан байна. Үүнд:

Цэвэр хураамжийн орлого 23.5 хувиар өсч 23.6 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарын цэвэр хураамжийн орлогын 12.5 хувийг эзэлж даатгалын салбартаа 2-т жагсаж байна. Цэвэр хураамжийн орлогын 78.6 хувийг гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгал бүрдүүлж байна.

Гэрээний хугацаагаар хувь тэнцүүлж тооцсон хураамж буюу орлогод тооцсон хураамжийн хэмжээ 19.9 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оноос 16.9 хувиар өссөн байна. Орлогод тооцсон хураамжийн хэмжээ өссөн хэдий ч нөхөн төлбөрийн цэвэр зардлын хэмжээ 35,1 хувиар буюу 3.1 тэрбум төгрөгөөр өсч улмаар андеррейтингийн эрсдэл нэмэгдсэнээс үүдэн нөөц сангийн хэмжээг нэмэгдүүлсэн нь ашигт ажиллагаанд шууд сөрөг нөлөөлсөн.

### Төлбөрийн чадварын үзүүлэлт

Давхар даатгалын хойшлогдсон хураамж болон нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассан даатгагчийн цэвэр хөрөнгийн хэмжээ 27.8 тэрбум төгрөг байна. Нийт цэвэршүүлсэн хөрөнгийн 19.6 хувь буюу 5,4 тэрбум төгрөгийг зөвшөөрөгдөхгүй хөрөнгө эзэлж байна. 2022 оны төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт 100.49 хувь гарсан байна.

### Нөөцийн сан

2022 оны байдлаар нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ 4.18 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 31.5 хувиар буюу 1.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс 6.3% буюу 264.3 сая төгрөгийг давхар даатгагчид ногдох нөөц сан бүрдүүлж байна.

Нөөц сангийн өсөлтөд учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн нь нийт нөхөн төлбөрийн зардлын хэмжээ өмнөх оноос 36 хувиар буюу 3.8 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Компанийн цэвэр хосолсон харьцаа 120.7% гарсан ба үүнтэй холбоотойгоор 1.4 тэрбум төгрөгийн учирч болзошгүй хохирлын нөөц сан нэмж байгуулсан. Тус нөөц сан өндөр байгуулагдсан нь Тээврийн хэрэгслийн даатгал, гэнэтийн ослын даатгал, зээлийн даатгал болон жолоочийн хариуцлагын даатгалын хувьд хосолсон харьцаа өндөр гарсантай холбоотой.

Цаашид даатгалын андррейтингийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж даатгуулагч тус бүрд тохирсон хураамжийг өөрчлөлтийг санал болгох замаар даатгалын хэлбэрийг төрөлжүүлж, хосолсон харьцааг бууруулж ашигт ажиллагаанд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

**Ашигт ажиллагаа, эцсийн үр дүн:**

Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөгөөр 6,7 т.б-ын ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,3 т.б –ын алдагдалтай ажилласан байх энэхүү алдагдалд бүтээгдэхүүний үнийн өсөлтийн улмаас нөхөн төлбөрийн дүн тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэсэн тайлбарыг удирдлага өгсөн хэдий ч энэ нь хангалттай үндэслэл болохгүйгээс гадна эрсдлийг удирдаж чадаагүй буюу даатгалын бүтээгдэхүүний хяналтыг сулруулсан, гүйцэтгэх удирдлагын багийн зүгээс бүтээгдэхүүний хохирлын харьцааг оновчтой түвшинд барих ажлыг цаг алдалгүй зохион байгуулж ажиллаж чадаагүй, хангалтгүй ажилласан гэж дүгнэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 28/02

Улаанбаатар хот

### Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх хэсгийг удирдлага болгон 2023 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
  - Лувсанвандан овогтой Болдхуяг
  - Ширчин овогтой Сүхбаатар
  - Ганбаатар овогтой Саруул
  - Болдхуяг овогтой Билэгт
  - Шонуунорсон овогтой Бэжид
  - Данзан овогтой Даянбилгүүн нарыг сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
  - Эрдэнэ овогтой Бямбажав
  - Лхагвасүрэн овогтой Банзрагч
  - Батчулуун овогтой Бүжинлхам нарыг сонгохыг зөвшөөрсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 25/08

Улаанбаатар хот

### Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах хэсгийг удирдлага болгон 2023 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг “Хавсралт №1”-т заасны дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР



“Бодь даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №23/03 тоот тогтоолын Хавсралт №1

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, үйл ажиллагааны зардлыг дараах байдлаар тогтоов.

№	Зардлын төрөл	Төсөв	Хүний тоо	Нийт
1	ГУЗ-ийн ердийн гишүүдийн цалин	700,000	6	50,400,000
2	ГУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин	900,000	3	32,400,000
3	ГУЗ-ийн нарийн бичгийн цалин	550,000	1	6,600,000
4	ГУЗ-ийн гишүүдийн сургалт хөгжил бусад үйл ажиллагааны зардал	5000,000	1	5,000,000
<b>Нийт зардал</b>				<b>94,400,000</b>